



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/02/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2025 он	Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn Аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.	ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	5
2.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан /төгрөгөөр/	5
2.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	5
2.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	6
3.	Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1	Байгууллагын үйл ажиллагаа.....	Error! Bookmark not defined.
3.2	Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4	Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5	Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4.	АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1	Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2	Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.4.1	Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	Error! Bookmark not defined.
4.5	Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1	Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.5.1	Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	Error! Bookmark not defined.
4.6	Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5.	Аудитын илрүүлэлт.....	6
5.1	Төлбөрийн акт	7
5.2	Албан шаардлага.....	7
5.3	Зөвлөмж	7
9.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХСУХАТАҮЗЗ	Хот суурины усан хангамж ариутган татуурга үйлчилгээний зохицуулах зөвлөл
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сүм
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

4825.03.14

№

77

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

“Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт, хандиваар ирсэн хөрөнгийг нэмж бүртгэсэнтэй холбоотой бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. 2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусгаж, батлуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4825020265

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	23,105.96	24,939.38
1.1.02	Дансны авлага	13,854,116.00	8,990,754.98
1.1.06	Бараа материал	201,110,244.20	147,383,314.21
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	214,987,466.16	156,399,008.57
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,963,682,514.47	10,883,811,392.48
1.2.02	Биет бус хөрөнгө	2,444,496,000.00	2,446,212,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,408,178,514.47	13,330,023,392.48
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,623,165,980.63	13,486,422,401.05
2.1.1.01	Дансны өглөг	0.00	20,000.00
2.1.1.02	Цалингийн өглөг	5,999.99	0.00
2.1.1.03	Татварын өр	104,701.43	2,547,272.36
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	26,372,438.98
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	110,701.42	28,939,711.34
2.2	Өр төлбөрийн нийт дүн	110,701.42	28,939,711.34
2.3.02	- хувийн	4,510,678,390.35	5,859,536,050.31
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,392,680,917.98	3,392,680,917.98
2.3.09	Хуримтлагдсан ашиг	5,719,695,970.88	4,205,265,721.42
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-1,514,430,249.46
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	5,719,695,970.88	5,719,695,970.88
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,623,055,279.21	13,457,482,689.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,623,165,980.63	13,486,422,401.05

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	380,000.00	3,814,000.00
02	Борлуулалтын өртөг	2,019,931,424.74	2,652,977,686.79
03	Нийт ашиг(алдагдал)	-2,019,551,424.74	-2,649,163,686.79
04	Түрээсийн орлого	1,875,000.00	8,972,000.00
08	Бусад орлого	975,509,778.42	1,542,253,497.40
08.1	Орлогын дүн	977,384,778.42	1,551,225,497.40
10	Ерөнхий ба удирдлагын зардал	345,122,604.24	424,265,315.61
12.1	Зардлын дүн	345,122,604.24	424,265,315.61
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-69,196,512.89	-14,192,744.46
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	21,966,000.00
17.1	Олз, гарзын дүн	-69,196,512.89	7,773,255.54
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,456,485,763.45	-1,514,430,249.46
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,456,485,763.45	-1,514,430,249.46
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,456,485,763.45	-1,514,430,249.46

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	2,374,761,977.98	3,392,680,917.98	7,176,181,734.33	12,943,624,630.29
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-1,456,485,763.45	-1,456,485,763.45
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	2,135,916,412.37	0.00	0.00	2,135,916,412.37
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	4,510,678,390.35	3,392,680,917.98	5,719,695,970.88	13,623,055,279.21

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-1,514,430,249.46	-1,514,430,249.46
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	1,348,857,659.96	0.00	0.00	1,348,857,659.96
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,859,536,050.31	3,392,680,917.98	4,205,265,721.42	13,457,482,689.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	933,462,419.36	1,556,043,868.40
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	935,000.00	2,682,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	919,489,900.00	1,447,484,750.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	13,037,519.36	105,877,118.40
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	929,175,361.40	1,525,944,034.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн	478,970,158.35	910,344,043.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	83,732,907.40	105,613,534.27
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	31,948,270.00	94,967,140.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	105,317,300.27	155,695,032.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	148,032,655.00	128,580,480.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	38,262,937.07	70,448,414.30
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,000,000.00	6,000,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	36,911,133.31	54,295,390.61
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,287,057.96	30,099,833.42
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,960,000.00	30,098,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,960,000.00	28,118,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	1,980,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,960,000.00	-30,098,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	303,952.00	0.00
3.2.5	Бусад	303,952.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-303,952.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	23,105.96	1,833.42
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	23,105.96
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,105.96	24,939.38

3. Аудитын илрүүлэлт

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 195.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд нийт орлогыг 195.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;

Залруулагдаагүй алдаа, зөрчил:

Аудитаар нийт 509,093.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 930.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12,686.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлэн, 495,476.7 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

- Түрээсийн орлогоос орон нутгийн орлогод төвлөрүүлэх 930.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй. Энэ нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 2.5-д /Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 70 хувийг Байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 30 хувийг Төрийн сангийн Хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны сүүлийн сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгнө/ заасныг зөрчсөн.

3.2 Албан шаардлага

- Бусдад ашиглагдаж байгаа 3,696.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд үлдэгдлээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг;
- Шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг цалингийн зардлаас гаргаж авлагаар бүртгэсэн ч холбогдох буруутай албан тушаалтнаар 8,990.8 мянган төгрөгийг нөхөн төлүүлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх/, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д /Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ/, Иргэний хуулийн 498.1-т /Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ/, 498.5-д /Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй/ заасныг тус тус зөрчсөн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Биетээр байхгүй 495,476.7 мянган төгрөгийн бетон хучилттай автозамыг үлдэгдлээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Биетээр байхгүй хөрөнгийг холбогдох хуль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэн арга хэмжээ авч, жилийн эцсийн санхүүгийн тайланд хэрэгжилтийг ирүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилт:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар давтан шалгахад хөрөнгөтэй холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд нийт орлогыг илүү тайлагнасан	1	195.5			1	195.5	1	195.5				
Дүн	1	195.5	-	-	1	195.5	1	195.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага		Хуулийн байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн							тооцуулах			
Түрээсийн орлогоос орон нутгийн орлогод төвлөрүүлэх 30 хувийг төвлөрүүлээгүй.	1	930.0	1	930.0								
Бусдад ашиглагдаж байгаа хөрөнгийг бүртгэлд үлдэгдлээр тайлагнасан. /Смарт дэлгэц/	1	3,696.0			1	3,696.0						
Биетээр байхгүй бетон хучилттай автозамыг үлдэгдлээр тайлагнасан.	1	495,476.7					1	495,476.7				
Шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг цалингийн зардлаас гаргаж авлагаар бүртгэсэн ч холбогдох буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй.	1	8,990.8			1	8,990.8						
Дүн	4	509,093.5	1	930.0	2	12,686.8	1	495,476.7	-	-	-	-